

Баянзүрх дүүрэг "Хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн ба хэрэгцээ шаардлага" Түргэвчилсэн судалгаа

2022 оны 7-р сар



© З.Эрдэнэ

Агуулга

| | |
|---|----|
| Удиртгал ба аргачлал | 1 |
| Мэдээллийн дүн шинжилгээ..... | 2 |
| 1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм..... | 2 |
| 1.2 Ирсэн иргэд..... | 3 |
| 1.3 Явсан иргэд..... | 3 |
| 1.4 Хөдөлмөр эрхлэлт..... | 4 |
| 1.5 Санхүүгийн нөхцөл байдал..... | 5 |
| 1.6 Тулгамдаж буй асуудал, аюулгүй байдал..... | 6 |
| 1.7 Үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц..... | 10 |
| 1.8 Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж..... | 14 |
| 1.9 Тээвэр, замын хөдөлгөөний нөхцөл байдал..... | 15 |
| 1.10 Хүүхэд болон боловсрол..... | 16 |

Удиртгал ба аргачлал

Удиртгал

Дүүргийн түвшний энэхүү тайланд 2022 оны 3-р сард Улаанбаатар хотын хэмжээнд хүн ам, шилжилт хөдөлгөөн, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох шуурхай үнэлгээнд тусгагдсан үндсэн болоод сэдэвчилсэн бүх чиглэлийн тойм мэдээллийг багтаасан болно.

Энэхүү тайлан нь Баянзүрх дүүргийн хэмжээнд найман үндсэн сэдвийг хамарсан судалгааг багтаасан; тухайлбал, хүн амын суурь тоон үзүүлэлт, хүн ам зүй, ирсэн болон явсан иргэд (шилжилт хөдөлгөөн), хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлууд ба аюулгүй байдал, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, хүүхэд болон боловсрол гэх мэт. Мэдээллийг дүүргийн нутаг дэвсгэр, хүний нөөц, засаг захиргааны нэгжийн харилцааны талаарх мэдлэг өндөртэй мэдээлэл нэгтгэгчид болох хэсгийн ахлагч нартай ярилцлага хийх замаар олж авсан.

Энэхүү судалгааны үндэслэл, хэрэгцээ шаардлагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг Улаанбаатар хотын дэлгэрэнгүй тайлангаас авч үзнэ үү.

Аргачлал

Энэхүү тайланд ОУШХБ-ын Шилжих хөдөлгөөнийг тандах матриц (ДТМ)-ийн нэгжээс боловсруулсан хөдөлгөөнийг тандах (МТ) аргачлалыг ашигласан болно.

Судалгаанд хөдөлгөөнийг тандах (МТ) аргачлалыг ашигласан Улаанбаатар хотын хамгийн жижиг засаг захиргааны нэгж болох хэсгийн түвшинд хэсгийн ахлагч нараас мэдээллийг цуглуулав. Хэсгийн ахлагч нар иргэдтэй ярилцах, ажиглалт хийх болон өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан, харилцаа холбооны хэрэгслүүдийг ашиглан тоон мэдээллийг нягтлах, баталгаажуулах ажлыг хийхээр төлөвлөсөн юм. Хэсгийн ахлагч нарыг хүн амын суурь тоон үзүүлэлт, шилжин ирэгсэд ба явагсад, хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, аюулгүй байдал, үйлчилгээний хүртээмж болон дэд бүтэц, ногоон байгууламж, хүүхэд ба боловсрол гэсэн найман үндсэн сэдвийг багтаасан судалгааны асуулгыг бөглөхийг хүссэн юм.

Хэсгийн ахлагч нар Кобо программ хамгамжаар дамжуулан тоон мэдээллийг гар утас эсвэл таблет, компьютер ашиглан бөглөж илгээсэн. Хэсгийн ахлагч нарыг ДТМ судалгааны аргачлал, судалгааны асуулга, түүнийг нөхөхтэй холбоотой танхимын сургалтад бүрэн хамруулсан. Түүнчлэн ДТМ-ийн баг мэдээлэл цуглуулах явцад үүссэн аливаа асуулт, асуудалд цаг тухайд нь хариу өгч бэлэн байдалд ажилласан юм.


Өгөгдөл оруулах үйл явц албан ёсоор хаагдмагц ДТМ-ийн баг бүрэлдэхүүн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлсэн бөгөөд өгөгдөл оруулахад гарч болзошгүй алдаа, тоон мэдээллийн зөрүү, давхардал зэргийг илрүүлэхийн тулд өгөгдлийн хяналтын шатанд чанарын баталгаажуулалтын шалгалтыг хийсэн. Өгөгдөлтэй холбоотой аливаа асуудал илэрсэн тохиолдолд ДТМ-ийн баг тодруулга авахаар хэсгийн ахлагч нартай утсаар холбогдож тоон мэдээллийг тодруулж, баталгаажуулсан байна. Бүх хяналт, шалгалтыг хийж дууссаны дараа мэдээлэлд дүн шинжилгээ хийх үе шатанд шилжсэн. Бүх судалгааны үр дүнг хэсгийн түвшинд дүн шинжилгээ хийж, дараа нь дүүргийн болон хотын хэмжээнд нэгтгэн дүгнэв. Иймээс дүүрэг, хотын түвшинд энэхүү тайланд тусгагдсан аливаа үр дүнг хэсгийн түвшинд ч авах боломжтой гэдгийг дурдах нь зүйтэй юм.

Хязгаарлагдмал байдал, судалгааны аргачлалын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг Улаанбаатар хотын хэмжээний нэгдсэн тайлангаас үзнэ үү.




1. МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ - БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ

1.1 Хүн амын суурь тоон үзүүлэлт ба хүн ам зүйн тойм



Хүн ам зүй (эзлэх хувь)




Үнэлгээ хийх үед (2022 оны гуравдугаар сар) Баянзүрх дүүрэгт 356,807 иргэн буюу 96,105 өрх бүртгэгдсэн байна. Баянзүрх дүүрэг нь Улаанбаатар хотын хэмжээнд хамгийн их хүн амтай дүүрэг бөгөөд нийслэлийн нийт хүн амын 24 хувийг дангаараа эзэлдэг. Баянзүрх дүүргийн нийт хүн амын 47 хувь нь эрэгтэй, 53 хувь нь эмэгтэй юм. Хүн амын 34 хувь нь хүүхэд гэж бүртгэгдсэн байна: 12 хувь нь 0-5 насныхан, 22 хувь нь 6-17 насныхан байна. Хүн амын 60 хувийг 18-65 насны насанд хүрэгчид, 6 хувийг өндөр настан (65-аас дээш насныхан) эзэлж байна гэж мэдээлжээ.

Нийт 6,073 хүн архаг эсвэл хүнд өвчтэй (хүн амын 1,7%), 4,193 эмэгтэй жирэмсэн (эмэгтэйчүүдийн 2,2%) байна.

Баянзүрх дүүрэг нь 28 хороо, 395 хэсэгтэй. Хамгийн олон хүн амтай 14, 16, 26 дугаар хороод тус бүр дүүргийн хүн амын 7 хувийг эзэлдэг байна.


Хүн ам зүйн тойм хүйсээр, хороогоор (эзлэх хувь)



1.2 Ирсэн иргэд²

2021 онд Баянзүрх дүүрэгт нийт 9,843 өрх буюу 29,361 иргэн ирсэн байна. 2021 онд Улаанбаатар хотод нийт ирсэн иргэдийн 24.5 хувь нь Баянзүрх дүүрэгт бүртгэгдсэн нь нийслэлийн хэмжээнд хамгийн олон хүн ирсэн дүүрэг болсон байна. Ирсэн хүмүүсийн хамгийн их хувийг 14-р хороо (19%) эзэлж байна. Энэ дүүрэгт ирсэн гол шалтгаан нь гэр бүлийн шалтгаан (30%), боловсрол (23%), эдийн засгийн шалтгаан (10%) байв.


Ирсэн иргэд хамгийн их бүртгэгдсэн хороо (ирсэн иргэдийн эзлэх хувь)



1.3 Явсан иргэд

2021 онд Баянзүрх дүүргээс нийт 3,811 өрх буюу 12,356 иргэн явсан. 2021 онд Улаанбаатар хотын хэмжээнд нийт 14.3 хувь нь Баянзүрх дүүргээс өөр дүүрэг, хороо, хэсэг эсвэл орон нутаг руу нүүсэн байна. Хамгийн их явсан иргэд 14 болон (23%), 9-р хороо (10%), 17-р хороо (9%) -ноос явсан бөгөөд ерөнхийдөө энэ дүүргээс явах хамгийн гол шалтгаан нь шинээр ашиглалтад орсон орон сууцанд амьдрах (28%) нүүсэн байна.

Явсан иргэд хамгийн их бүртгэгдсэн хороо (ирсэн иргэдийн эзлэх хувь)



Ирсэн, явсан үндсэн шалтгаанууд (эзлэх хувь)




² Ирсэн иргэд гэдэг нь Улаанбаатар хотын дотор эсвэл хотын гаднаас ирсэн эсэхээс үл хамааран Улаанбаатар хотын аль нэг байршилд оршин суухаар ирсэн иргэн, айл өрхийг хэлнэ. Явсан иргэд гэдэг нь Улаанбаатар хотын аль нэг байршлаас явсан эсэхийг үл хамааран явсан иргэн, айл өрхийг хэлнэ.


1.4 Хөдөлмөр эрхлэлтийн байдал

Баянзүрх дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зонхилох салбар нь бөөний болон жижиглэнгийн худалдаа (хэсгүүдийн 33%-д), барилга (22%), төрийн алба, батлан хамгаалах (11%) салбар байна. Бөөний болон жижиглэнгийн худалдаа 14-р хороо (хэсгүүдийн 94%), 6-р хороо (хэсгүүдийн 89%), 18-р хороо (хэсгүүдийн 83%-нд хамгийн өндөр бүртгэгдсэн байна. Баянзүрх дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн хоёр дахь үндсэн салбар болох барилга нь 27-р хороо (72%), 21-р хороо (65%), 12-р хороо (59%) -нд хамгийн их бүртгэгджээ. Дүүргийн хэмжээнд хамгийн их хүн амтай (26,618 хүн амтай; дүүргийн хүн амын 7%) 26-р хороонд хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар нь үйлдвэрлэл (хэсгүүдийн 37%) байна. Бөөний болон жижиглэнгийн худалдаа хамгийн түгээмэл хөдөлмөр эрхлэлтийн салбар бөгөөд 131,895 хүн амыг хамарч байна (дүүргийн хүн амын 37%). Харин барилгын салбарт хөдөлмөр эрхэлж байгаа хүн ам 71,378 (дүүргийн хүн амын 20%) Баянзүрх дүүрэгт бүртгэгджээ.


Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбар (хэсгийн эзлэх хувь)




Хөдөлмөр эрхлээгүй хүн ам (18-64 насны иргэдийн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь, хороогоор (18-64 насны иргэдийн эзлэх хувь)



Хөдөлмөр эрхлэлтийн төрөл (хэсгийн эзлэх хувь)



Баянзүрх дүүргийн хэмжээнд 18-64 насны 70,249 хүн хөдөлмөр эрхлээгүй байгаа нь насанд хүрсэн хүн амын 33 хувийг эзэлж байна. Энэ дүүрэгт хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь Улаанбаатар хотын хэмжээнд гуравдугаарт орсон (хотын дунджаас гурван хувиар илүү) байна. Түүнчлэн Баянзүрх дүүрэг нь нийслэлийн бусад дүүргүүдтэй харьцуулахад хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь хамгийн өндөртэй байна. Тиймээс Улаанбаатар хотын хамгийн их хүн амтай буюу нийслэлийн хүн амын 24 хувь нь оршин суудаг дүүрэгт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь маш чухал юм. 28-р хороо (47%), 27-р хороо (45%), 19-р хороонд (45%) хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь хамгийн өндөр байв. Эдгээр гурван хороонд хөдөлмөрийн насны хүн ам 17,527 байгаагаас 8,014 иргэн хөдөлмөр эрхлээгүй гэж мэдээлсэн. Харин эсрэгээрээ 9-р хороо (14%), 13-р хороо (16%), 20-р хороо (22%-нд хөдөлмөр эрхлээгүй хүн амын эзлэх хувь хамгийн бага бүртгэгджээ. Эдгээр гурван хороонд хөдөлмөрийн насны нийт 19,480 иргэн байгаагаас 16,304 иргэн хөдөлмөр эрхэлж байна.

Баянзүрх дүүргийн хэмжээнд нийт иргэдийн 63 хувь нь хувийн хэвшил, 22 хувь нь төрийн байгууллага, 11 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 1 хувь нь өдрөөр цалинждаг хөдөлмөр эрхэлдэг, үлдсэн 1 хувь нь мал аж ахуй эрхэлдэг тухай мэдээлжээ. Тиймээс Баянзүрх дүүрэгт хувийн хэвшлийн хөдөлмөр эрхлэлт хотын дунджаас таван хувиар бага, төрийн алба нь хотын дунджаас долоон хувиар илүү байна. Хувийн хэвшлийн харьцангуй бага хувь нь дүүргийн хэмжээнд хөдөлмөр эрхлэгчид хөдөлмөр эрхлээгүй хүн амын дунджаас өндөр байгааг тайлбарлаж болох юм. 21-р хороо (100%), 27-р хороо (94%), 12-р хороо (88%-нд хувийн хэвшилд хөдөлмөр эрхлэлт хамгийн их бүртгэгдсэн байгаа бол 3-р хороо (100%), 4-р хороо (85%), 1-р хороонд (67%) төрийн албанд хөдөлмөр эрхлэлт зонхилж байна.


1.5 Санхүүгийн нөхцөл байдал

Энэ хэсэгт орлогын бууралт болон хүнсэнд зарцуулах зардлын бууралттай холбоотой асуудлаар мэдээлэл нэгтгэгчдийн ажиглалтыг авч үзэх замаар төлбөрийн чадварыг судалсан болно.

Нийт Баянзүрх дүүргийн хэсгүүдийн 20 хувьд мэдээлэл цуглуулагчид мэдээлэл цуглуулахаас дөрвөн долоо хоногийн өмнө айл өрхүүд хангалттай хоол идэхгүй байна гэж санаа зовниж байгаагаа мэдээлсэн нь нийт 65,388 хүн амыг хамраад байна. Энэ үзүүлэлт нь нийслэлийн дундаж 29 хувиас есөн хувиар бага байна. 23-р хороо хамгийн эмзэг байгаа бөгөөд хэсгийн мэдээлэл нэгтгэгчдийн 75 хувьд нь хоол хүнс хүрэлцэхгүй байна гэж санаа зовниж байгаа талаар мэдээлжээ.

Хэсгүүдийн 23 хувьд нь мэдээлэл нэгтгэгчид мэдээлэл цуглуулахаас дөрвөн долоо хоногийн өмнө айл өрхүүд хүнсний хэрэглээгээ багасгасан тухай сонссон гэж мэдээлсэн нь нийт 81,397 хүнтэй тэнцүү юм. Энэ үзүүлэлт нь нийслэлийн дундаж 34 хувиас 11 хувиар бага юм. 7-р хороонд хамгийн өндөр байгаа бөгөөд хэсгүүдийн 78 хувьд нь мэдээлэл нэгтгэгчид айл өрхүүд хүнсний зардлаа бууруулж байгаа тухай гэж сонссон байна.

Сүүлийн 4 долоо хоногт орлого нь буурсан иргэд (хэсгийн эзлэх хувь)



Баянзүрх дүүргийн 90 хувьд нь мэдээлэл нэгтгэхээс өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд орлого буурсан иргэд байхгүй эсвэл бараг байхгүй гэж мэдээлсэн байна. Гэсэн хэдий ч, хэсгүүдийн 10 хувьд нь оршин суугчдын тал буюу талаас илүү хувь нь орлого буурсан байв. Энэ нь дүүргийн нийт хүн амын 31,998 хүнийг хамарч байна. Хэсгүүдийн 92 хувьд нь мэдээлэл нэгтгэхээс өмнөх дөрвөн долоо хоногийн хугацаанд бүх орлогоо алдсан хүн байхгүй гэж мэдээлсэн байна. Хэсгүүдийн найман хувьд оршин суугчдын тал болон талаас илүү хувь буюу 25,555 хүн бүх орлогоо алдсан байдалтай байгааг мэдээлсэн байна.

Хүнсний аюулгүй байдал (хэсгийн эзлэх хувь)


Хүнсний хэрэглээ хангалтгүй байгаад санаа зовних



Хүнсний хэрэглээгээ багасгасан




Сүүлийн 4 долоо хоногт бүх орлогоо алдсан иргэд (хэсгийн эзлэх хувь)



1.6 Тулгамдаж буй асуудал болон аюулгүй байдал

Баянзүрх дүүргийн хэмжээнд хамгийн их тулгамдсан асуудал бол санхүү, эдийн засгийн тогтворгүй байдалтай холбоотой байв. Хамгийн ихээр мэдээлсэн бэрхшээл бол орлого хангалтгүй (хэсгүүдийн 43%-д мэдээлсэн), хөдөлмөр эрхэлдэггүй хүн амын эзлэх хувь өндөр (24%), өр, зээл (14%) юм. 10, 16-р хороодод орлого хангалтгүй байгаа нь хамгийн өндөр бүртгэгдсэн бөгөөд энэ нь хэсгүүдийн 80 хувьд байв.


Тулгамдаж буй асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




Баянзүрх дүүргийн хэмжээнд иргэдэд хамгийн хүндрэлтэй байсан үйлчилгээ нь авто машины зогсоолын хүртээмж муу (19%), амьжиргаа, ажлын байр/орлого бий болгох боломж муу (19%), эрүүл мэндийн үйлчилгээ хүртээмж муу (15%) байдал байв. 6-р хорооны хэсгүүдэд 78 хувь нь авто машины зогсоолын хүртээмж нэн тэргүүнд анхаарал хандуулдаг асуудал гэж мэдээлсэн. 3-р хорооны бүх хэсгүүдэд иргэдийн амжиргаа, ажлын байр/орлого бий болгох боломжийг нэмэгдүүлэх нь нэн тэргүүнд анхаарал хандуулах асуудал гэж мэдээлжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч буй гол бэрхшээл нь гудамж, цэцэрлэгт хүрээлэн, барилга байгууламжид аюулгүй нэвтрэх дэд бүтэц дутмаг (44%), дараа нь тусгай зориулалтын эмнэлгийн тусламж үйлчилгээ дутмаг (29%) байна гэж мэдээлжээ.


Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгамдаж буй асуудал (хэсгийн эзлэх хувь %)



Хүндрэлтэй байдаг үйлчилгээ (хэсгийн эзлэх хувь)




Аюулгүй байдал, хороогоор (Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш сайн)



Аюулгүй байдлыг хөндсөн асуудал гарсан эсэх (хэсгийн эзлэх хувь)


Аюулгүй байдлыг хөндсөн асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




1.7 Дэд бүтэц, үйлчилгээ

УС

Усны хэрэглээгүй байгаа хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Устай холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ

Цахилгааны хэрэглээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Цахилгааны хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ХООЛ ХҮНС

Хүнсний бүтээгдэхүүн хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Хүнсний бүтээгдэхүүн хүрэлцээтэй тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ОРОН БАЙР

Орон байрны хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Орон байртай холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




1.7 Дэд бүтэц, үйлчилгээ

ХҮНСНИЙ БУС ЗҮЙЛС

Хүнсний бус бүтээгдэхүүн хүрэлцээгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Хүнсний бус бүтээгдэхүүнтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ИНТЕРНЭТ

Интернэтэд холбогдоогүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Интернэтийн хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжгүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)




Эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




УХААЛАГ УТАС

Ухаалаг утас ашигладаггүй хүмүүс (хэсгийн эзлэх хувь)



Ухаалаг утасны хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)




1.8 Ногоон байгууламж

Мэдээлэл нэгтгэгчээс өөрийн хэсгийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанарт нэгээс тав хүртэл, нэг нь маш муу, тав нь маш сайн гэсэн үнэлгээ өгөхийг хүссэн. Баянзүрх дүүргийн бүх төрлийн ногоон байгууламжийн чанар нэлээд муу байв. Өрхийн ногоон байгууламжийн чанар 20-р дугаар (3.4) хэсэгт хамгийн өндөр, 7 дугаар хэсэгт (1.6) хамгийн бага байв. Хувийн хэвшлийн ногоон байгууламжийн чанар 15-р хэсэгт хамгийн өндөр (3.1), 21-р хэсэгт (1.2) хамгийн бага байв. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн чанар 18-р хэсэгт хамгийн өндөр (3.1), мөн 21-р хэсэгт (1.2) хамгийн бага байна.


Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар (хэсгийн эзлэх хувь)

Оноо: 1= маш муу, 2= муу, 3= дундаж, 4= сайн, 5= маш


Өрхийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар



Хувийн хэвшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар




Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн чанар




| Хороо # | Өрхийн ногоон байгууламж | Хувийн хэвшлийн ногоон байгууламж | Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж |
|-----------|--------------------------|-----------------------------------|-------------------------------------|
| Хороо #1 | 2.7 | 2.4 | 2.6 |
| Хороо #2 | 1.9 | 1.9 | 1.6 |
| Хороо #3 | 2.0 | 2.0 | 2.0 |
| Хороо #4 | 2.8 | 2.8 | 2.8 |
| Хороо #5 | 2.3 | 2.2 | 2.2 |
| Хороо #6 | 2.3 | 2.3 | 2.3 |
| Хороо #7 | 1.6 | 1.7 | 1.7 |
| Хороо #8 | 2.2 | 2.0 | 2.1 |
| Хороо #9 | 2.2 | 1.6 | 1.4 |
| Хороо #10 | 2.0 | 2.1 | 1.9 |
| Хороо #11 | 2.5 | 2.5 | 2.5 |
| Хороо #12 | 1.9 | 2.3 | 2.0 |
| Хороо #13 | 2.0 | 2.3 | 2.4 |
| Хороо #14 | 2.3 | 2.4 | 2.4 |
| Хороо #15 | 3.0 | 3.1 | 3.0 |
| Хороо #16 | 2.4 | 2.4 | 2.3 |
| Хороо #17 | 1.6 | 1.5 | 1.4 |
| Хороо #18 | 2.7 | 2.9 | 3.1 |
| Хороо #19 | 2.4 | 2.3 | 2.3 |
| Хороо #20 | 3.4 | 2.4 | 2.6 |
| Хороо #21 | 1.8 | 1.2 | 1.2 |
| Хороо #22 | 2.2 | 2.4 | 2.3 |
| Хороо #23 | 2.0 | 2.3 | 2.1 |
| Хороо #24 | 2.0 | 1.5 | 1.5 |
| Хороо #25 | 2.2 | 2.1 | 1.9 |
| Хороо #26 | 3.0 | 2.9 | 2.9 |
| Хороо #27 | 1.9 | 1.9 | 1.7 |
| Хороо #28 | 2.8 | 2.3 | 2.2 |

1.9 Зам тээвэр ба хөдөлгөөн


Хувийн тээврийн хэрэгсэлгүй өрх (хэсгийн эзлэх хувь)



Тээврийн үндсэн аргууд (хэсгийн эзлэх хувь)



Замын хөдөлгөөнтэй холбоотой үндсэн асуудлууд (хэсгийн эзлэх хувь %)



Замын хөдөлгөөнтэй холбоотой гарч болзошгүй бүх тулгамдсан асуудал Баянзүрх дүүрэгт бүртгэгдсэн байна. Зонхилох зорчих арга (хэсгүүдийн 48%) нь авто машин гэж мэдээлсэн байна. Дүүргийн хэмжээнд замын хөдөлгөөний хамгийн хүндрэлтэй асуудал нь ачаалал ихтэй (22%), дараа нь зогсоолын хүрэлцээ муу (20%) байна. Замын хөдөлгөөний ачаалал 13-р хороонд (92%) хамгийн их бүртгэгдсэн бол 16-р хороонд (80%) авто машины зогсоол дутмаг байна.



© Ү.Одбаяр

Уг тайлангийн үр дүн, дүгнэлт нь зөвхөн судалгааны багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд ОУШХБ, түүний гишүүн улсууд, Швейцарын хөгжлийн агентлаг болон бусад хандивлагчдын байр суурийг илэрхийлэхгүй болно. Тайлангийн туршид ашигласан тэмдэглэгээ болон материалын танилцуулга нь аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот, бүс нутгийн эрх зүйн байдлын талаар ОУШХБ-ын зүгээс ямар нэгэн үзэл бодлоо илэрхийлэх, эсхүл түүний эрх баригчид, хил хязгаарыг илэрхийлээгүй болно.

ОУШХБ нь шилжин суурьшигчид, хөдөлгөөнт хүн ам болон нийгэмд тустай, хүмүүнлэг, аюулгүй, цэгцтэй шилжилт хөдөлгөөний зарчмыг баримтлан ажилладаг. ОУШХБ нь засгийн газар хоорондын байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгийн түншүүдтэйгээ дараах зорилтын хүрээнд хамтран ажилладаг. Үүнд: Шилжилт хөдөлгөөний үйл явц дахь сорилтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх; шилжилт хөдөлгөөний асуудлын талаар мэдлэг мэдээллээ дээшлүүлэх; шилжилт хөдөлгөөнөөр дамжуулан нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих; мөн шилжин суурьшигчдын нэр төр, сайн сайхныг дээдлэх зэрэг болно.


Энэхүү тайлан нь Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр, ОУШХБ-аас хэрэгжүүлж буй “Монгол Улс дахь дотоод шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь” төслийн хүрээнд хийгдэж буй ажлуудаас гаргаж буй үр дүнгийн нэг хэсэг юм. Энэхүү төслийн зорилго нь Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицыг (ДТМ) ашиглан Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөн, хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх замаар нотолгоонд суурилсан томъёолол, хэрэгжилтийг бэхжүүлэн бататгахад оршино. Судалгааны аргачлал, арга зүй, дүн шинжилгээ, тайланг загварчлах ажлыг ОУШХБ-ын ДТМ хариуцсан ОУ-ын зөвлөх Витторио Бруни, дотоодын зөвлөх Ганбатын Гэрэлтогтох, туслах ажилтан Болор-эрдэний Маналцогзолын хамт боловсруулсан болно. Судалгааны асуулгыг ОУШХБ-ын баг, НЗДТГ-ын оролцоотойгоор боловсруулсан байна. Судалгааны мэдээллийг ОУШХБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн алба болон Глобал ДТМ-ийг дэмжих багийн удирдлагуудын техникийн дэмжлэгтэйгээр Хүн амын Хөдөлгөөнийг Тандах Матрицын (ДТМ) хэрэглүүрийг ашиглан цуглуулж, дүн шинжилгээ хийсэн болно.

1.10 Хүүхэд ба боловсрол



Баянзүрх дүүргийн хэмжээнд 0-5 насны 13,824 хүүхэд цэцэрлэгт хамрагдаагүй (тухайн насны хүн амын 33%), 6-17 насны 3,478 хүүхэд (тухайн насны хүн амын 4%) сургуульд хамрагдаагүй байна. Баянзүрх дүүрэгт 0-5 насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдаагүй түвшин, мөн 6-17 насны хүүхдийн сургуульд хамрагдаагүй тоо хамгийн өндөр хувьтай байна. 0-5 насны хүүхдүүдийн цэцэрлэгт хамрагдаагүй түвшин 3-р хороонд (83%) хамгийн өндөр, харин 6-17 насны хүүхдүүдийн боловсролд хамрагдаагүй түвшин 19-р хороонд (27%) хамгийн их нь байна.

Хүүхдүүдийн ерөнхий нөхцөл байдлыг илүү өргөн хүрээнд судлахын тулд мэдээлэл нэгтгэгчээс хүүхдүүдэд тулгардаг үндсэн асуудал өөрсдийн хэсгийн нутаг дэвсгэр дээр хэр байгаа талаар асуусан. Баянзүрх дүүргийн хэсгүүдийн 32 хувь нь боловсролтой холбоотой ямар ч асуудал байхгүй гэж хариулсан бол 27 хувь нь сургууль хэт хол, 27 хувь нь сургуулийн хүрэлцээ муу гэж хариулжээ. Дүүргийн хэмжээнд хүүхдүүдтэй холбоотой хамгийн их бүртгэгдсэн хоёр асуудал бол хүүхдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх клуб, спортын төв дутмаг (хэсгүүдийн 40%) болон сургууль хүртэлх зай хэт хол (20%) гэсэн байна.

Боловсролтой холбоотой тулгамдсан асуудлууд (хэсгийн эзлэх хувь)



Сургуульд хамрагдаагүй хүүхдүүд (хэсгийн эзлэх хувь %)



Хүүхдэд тулгамдаж буй асуудлууд (хэсгийн эзлэх хувь)

